



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2013 оны 04 сарын 08 өдөр

Дугаар A/67

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Ганцэцэг/-д, журмын хэрэгжилтийг зохион байгуулан дүнг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны хуралд хэлэлцүүлж байхыг Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв /Г.Бурмаа/-д тус тус даалгасугай.
3. Уг арга хэмжээнд шаардагдах зардлыг салбарын төвлөрсөн арга хэмжээний зардлаас төсөвт тусган гаргаж байхыг Санхүү, сангийн бодлого төлөвлөлтийн газар /С.Наранцогт/-т зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2011 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/44 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Я.САНЖМЯТАВ



Хөдөлмөрийн сайдын
2013 оны 1 дугаар сарын 16 -ны
өдрийн 16 дугаар тушаалын хавсралт

**“Эрүүл –Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч
байгууллага” шалгаруулах журам**

Нэг. Зорилго

1.1. Үйлдвэрлэлийн орчин нөхцлийг сайжруулж, ажилчдыг ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, бусад эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, санаачлагыг урамшуулан дэмжих, туршлагыг нь дэлгэрүүлэхэд энэ журмын зорилго оршино.

1.2. “Эрүүл - Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах журмыг Хөдөлмөрийн сайдын шагналын журамтай уялдуулан уг ажлын нэг хэсэг болгон зохион байгуулна.

Хоёр.Шалгаруулах үзүүлэлт

2.1. “Эрүүл - Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-ыг дараах үзүүлэлтээр шалгаруулна.

2.1.1 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр” болон ажлын байранд тавигдах Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /цаашид ХАБЭА гэх-/н шаардлага, стандарт, холбогдох бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусган зарцуулдаг байх;

2.1.2 Үйлдвэрлэлийн орчин, ажлын байрны нөхцөлд тодорхой ахиц дэвшил гарсан байх, ажилтан эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бурдүүлсэн байх, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр ажилчид хангагдсан байх;

2.1.3 Ажилчдыг урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал;

2.1.4 Үйлдвэрлэлийн зохион байгуулалтын дэг, журам, соёл тогтсон байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг бий болгосон байх;

2.1.5 ХАБЭА-н сургалтыг зохион байгуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгдөг, “Эрүүл –Аюулгүй ажлын байр”-ыг эрхэмлэж дэмжих үйл ажиллагааг сурталчилж, мэдээлдэг байх;

2.2 Дээрх үзүүлэлтүүдийг 100 онооны системээр дүгнэх ажлыг Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв зохион байгуулна.

Гурав. Шалгаруулах ажлын зохион байгуулалт

3.1. Аж ахуйн нэгж байгууллагуудыг “ЖИЖИГ” үйлдвэр, аж ахуйн нэгж /50 хүртэл ажилтантай/, “ДҮНД” үйлдвэр, аж ахуйн нэгж /51-199 хүртэл ажилчнитай/, “ТОМ” үйлдвэр, аж ахуйн нэгж /200-аас дээш ажиллагсадтай/ гэсэн 3 ангилал болгон шалгаруулалтанд оролцуулна.

3.2. “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах материалыг цаасан болон цахим хэлбэрээр жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн Хөдөлмөрийн нөхцөл, судлалын хэлтэс

/ХНСХ/-нд хүлээн авна. Шалгаруулалтад оролцох байгууллагууд дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

- ХАБЭА-н орчин, ажлын байрны нөхцлийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд авсан тодорхой арга хэмжээ, хүрсэн үр дүн, ахиц. /фото зураг, видео бичлэг, бусад хэлбэрээр баталгаажуулсан байх/
- “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах уралдааныг дүгнэх үзүүлэлт бүрээр гаргасан хэрэгжилтийн тайлан /ХЭМСТөвөөс гаргасан дүгнэх онооны үзүүлэлтийн дагуу гаргана./
- Харьяа орон нутаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэх талаар тодорхойлолт.
- Ажлын байрандаа хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгүүлсэн тухай дүгнэлт.
- Байгууллагын ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал.
- Тухайн онд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан талаарх аймаг, дүүргийн Мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт.

3.3. Хугацаа хожимдуулсан материалыг шалгаруулалтад оролцуулахгүй.

3.4. ХЭМСТөвийн захирлын шийдвэрээр журмыг дүгнэх ажлын хэсгийг байгуулж ажиллуулна. Ажлын хэсэгт холбогдох байгууллагуудын төлөөллийг оруулна.

3.5. Ажлын хэсэг ирүүлсэн материалыг бүртгэн хүлээн авч, шалгаруулалтыг хийж, дүгнэсэн дүнгээ ХАБЭА-н гурван талт үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлнэ.

3.6. Ажлын хэсгийн гишүүд шалгаруулах үзүүлэлтээр дүгнэгдэж, жагсаалтад орсон байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж болно.

Дөрөв. Шагнал, урамшуулал

4.1. Шалгуур үзүүлэлтийн дагуу “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах журмыг дүгнэж, онооны дарааллаар дараах байр эзлүүлнэ.

4.1.1. “ТОМ” үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага:

- 1-р байр. Нэг. Өргөмжлөл. 2,5 сая төгрөг
- 2-р байр. Нэг. Өргөмжлөл. 2 сая төгрөг.
- 3-р байр. Нэг. Өргөмжлөл. 1,5 сая төгрөг.

4.1.2. “ДҮНД” үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага :

- 1-р байр. Нэг. Өргөмжлөл. 2 сая төгрөг
- 2-р байр. Нэг. Өргөмжлөл. 1,5 сая төгрөг.
- 3-р байр. Нэг. Өргөмжлөл. 1 сая төгрөг.

4.1.3. “ЖИЖИГ” үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага:

- 1-р байр. Нэг. Өргөмжлөл. 1,5 сая төгрөг
- 2-р байр. Нэг. Өргөмжлөл. 1 сая төгрөг.
- 3-р байр. Нэг. Өргөмжлөл. 0,5 сая төгрөг.

4.2. “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан байгууллагуудад өргөмжлөл, мөнгөн шагналыг жил бүрийн 12 дугаар сард гардуулна.

4.3. “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах болон бусад аж ахуйн нэгж байгууллагуудад ажлын арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв хамтран зохион байгуулна.

